

## ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРААС ОРЛОГО ЧӨЛӨӨЛӨХӨД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. "Хувь хүн өөрийн орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар анх удаа хувьдаа орон сууцны барилга барих, эсхүл худалдан авахад зарцуулсан 30.0 сая төгрөгөөс дээшгүй хэмжээний хөрөнгөтэй тэнцэх орлого"-ыг чөлөөлөхдөө /ХХОАТТХ-ийн 16.1.12/

### ОРОН СУУЦНЫ ЧӨЛӨӨЛӨЛТ ЭДЛЭХ АНХНЫ ЖИЛД

Д/Д	Бүрдүүлэх бичиг баримт	Бүрдүүлэх баримтад тавигдах шаардлага	
1	Харьяа татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлж "Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр" авах /Хорооны тодорхойлолт, иргэний үнэмлэхний хуулбар, 2 хувь цээж зураг бүрдүүлж харьяа татварын албанаас авах /	Бичиг баримтыг өөрийн биеэр татварын албанд хүргэх. Дэвтэрт орлого олгон суутган тооцоолол хийсэн этгээд тэмдэглэл хийж, гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна. Хуулбарын хамт авч ирэх, Татварын улсын байцаагч эх хувьтай тулгаж, хуулбар дээр тэмдэг дарж баталгаажуулах  Дэвтэрт орлого олгон суутган тооцоолол хийсэн этгээд тэмдэглэл хийж гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Дэвтрийг нотариатаар гэрчлүүлсэн байх	
2	Харьяа татварын албанаас цахим татварын системд Хувь хүний орлогын албан татварын тайлан шивэх нууц үг авах	Татварын албаны e-tax.mta.mn сайтад хандан Хувь хүний орлогын албан татварын тайланг /ТТ-06 (а), ТТ-06 (б) / цахим татварын системээр тайлагнаж, тайланг хэвлэсэн байх	
3	Чөлөөлөлтөд хамрагдах иргэний 1. харьяа татварын албанд 2. санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид гаргасан хүсэлт	Тайлангийн маягт, өргөдлийн загвар хэсэгт байршуулсан нэгдсэн загвараар бичнэ. /татварын албанд гаргах хүсэлтэд орлогын эх үүсвэрийг тодорхой бичих, санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид гаргах хүсэлтэд банк, картын дугаар, дансны дугаарыг зөв бичих/	
4	Иргэний үнэмлэх, хуулбарын хамт	Иргэний үнэмлэхийг хуулбарын хамт авч ирэх, Татварын улсын байцаагч эх хувьтай тулгаж, хуулбар дээр тэмдэг дарж баталгаажуулах	Иргэний үнэмлэхийг нотариатаар гэрчлүүлсэн байх
5	Нийгмийн даатгалын дэвтэр, хуулбарын хамт	Нийгмийн даатгалын дэвтрийг хуулбарын хамт авч ирэх, Татварын улсын байцаагч эх хувьтай тулгаж, хуулбар дээр тэмдэг дарж баталгаажуулах	Нийгмийн даатгалын дэвтрийг нотариатаар гэрчлүүлсэн байх
6	Үл хөдлөх, эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ	Үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх газраас тухайн татвар төлөгч хувь хүнд олгосон "Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ"-г хуулбарын хамт авч ирэх, ТУБ эх хувьтай нь тулгаж,	Үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх газраас тухайн татвар төлөгч хувь хүнд олгосон "Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ"-г

		хуулбар дээр тэмдгээ дарж баталгаажуулна. Гэрчилгээг эх хувиар авч ирэх боломжгүй тохиолдолд нотариатаар гэрчлүүлсэн байх /Чөлөөлөлт эдлэхийг хүссэн хүний нэр гэрчилгээнд бичигдсэн байх/	нотариатаар гэрчлүүлсэн байх /Чөлөөлөлт эдлэхийг хүссэн хүний нэр гэрчилгээнд бичигдсэн байх/
7	Зээл олгосон банк, санхүүгийн байгууллагатай байгуулсан гэрээ, төлбөрийн баримтын хамт	Хувь хүн орон сууцны барилга барих, худалдан авахад зориулан зээл олгосон банк, санхүүгийн байгууллагатай хийсэн зээлийн гэрээг хуулбарын хамт авч ирэх, Татварын улсын байцаагч эх хувьтай тулгаж тэмдэг дарж баталгаажуулах	Хувь хүн орон сууцны барилга барих, худалдан авахад зориулан зээл олгосон банк, санхүүгийн байгууллагатай хийсэн зээлийн гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх
8	Орон сууцны захиалгын болон худалдах, худалдан авах гэрээ	Чөлөөлөлт эдлэх иргэний нэр дээр хийгдсэн гэрээ эх хувиараа байхгүй тохиолдолд нотариатаар гэрчлүүлсэн байх	
9	Орон сууц худалдан авах болон хувьдаа орон сууцны барилга барихад зарцуулсан орлогын эх үүсвэрийг нотлох баримт, мөнгө төлсөн баримт	Байрны төлбөр төлсөн баримт, төлбөрийн баримтын хуулбар, эх хувьтай тулгаж үзэх, орон сууц худалдан авахад оруулсан хөрөнгө нь татвар төлсний дараах орлого гэдгийг нотлох баримтууд байна. Орон сууц худалдан авах болон хувьдаа орон сууцны барилга барихад зарцуулсан хөрөнгө нь татвар төлсний дараах орлого гэдгийг нотлох шаардлагатай. Бэлэглэлийн орлого хүлээн авсан тохиолдолд бэлэглэгчтэй гэрээ байгуулан нотариатаар гэрчлүүлсэн байх бөгөөд бэлэглэгчийн нийгмийн даатгалын болон, иргэний орлого татварын бүртгэлийн дэвтрийг эх хувийг хуулбарын хамт авч ирэх	Байрны төлбөр төлсөн баримтын хуулбар, эх хувьтай тулгаж үзэх, орон сууц худалдан авахад оруулсан хөрөнгө нь татвар төлсний дараах орлого гэдгийг нотлох баримтууд байна. Орон сууц худалдан авах болон хувьдаа орон сууцны барилга барихад зарцуулсан хөрөнгө нь татвар төлсний дараах орлого гэдгийг нотлох шаардлагатай. Бэлэглэлийн орлого хүлээн авсан тохиолдолд бэлэглэгчтэй гэрээ байгуулан нотариатаар гэрчлүүлсэн байх бөгөөд бэлэглэгчийн нийгмийн даатгалын болон, иргэний орлого татварын бүртгэлийн дэвтрийг нотариатаар гэрчлүүлсэн байх
10	Хөрөнгийн үнэлгээний тайлан	Хэрэв хувь хүн орон сууцны барилгыг барьсан бол хөрөнгийн үнэлгээний байгууллагаар үнэлүүлсэн тайлан, үнэлүүлээгүй тохиолдолд уг барилгыг барихад зарцуулсан анхан шатны хүчин төгөлдөр баримтуудын жагсаалт үйлдэн хавсаргасан байх	
11	Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар төлсөн баримт	Татвар төлөгч иргэн, хувь хүний өмчилж байсан орон сууцыг худалдан авсан тохиолдолд орон сууцаа худалдсан этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны 2%-ийн албан татвар төлсөн баримт байна.	
12	Ажил олгогчоос олгосон цалингийн тооцооллын хүснэгт	Хүснэгтэд овог нэр, албан тушаал, цалингийн дүн, суутгуулсан албан татварын мэдээллийг оруулж санхүүгийн тэмдэг, гарын үсгээр баталгаажсан байх	

**ОРОН СУУЦНЫ ЧӨЛӨӨЛӨЛТИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ЭДЛЭХ ДАРААГИЙН  
ЖИЛҮҮДЭД**

Д/д	Бүрдүүлэх баримт бичиг	Бүрдүүлэх баримтад тавигдах шаардлага	
		Бичиг баримтыг өөрийн биеэр татварын албанд авчрах	Шуудангаар хүргүүлэх
1	Харьяа татварын албанаас татварын цахим тайлангийн системд тайлан шивэх нууц үг авах	Хувь хүний орлогын албан татварын тайлан ТТ-06 (а), ТТ-06 (б) маягыг цахим татварын системээр тайлагнаж, тайланг хэвлэсэн байх	
2	Чөлөөлөлтөд хамрагдах иргэний 1. харьяа татварын албанд 2. санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид гаргасан хүсэлт	Хүсэлтийг www.mta.mn сайтад Хувь хүн цэсний ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлт дотор Тайлангийн маягт, өргөдлийн загвар хэсэгт байршуулсан нэгдсэн загвараар бичнэ. /татварын албанд гаргах хүсэлтэд чөлөөлөгдөх орлогын эцсийн үлдэгдэл, хэд дэх жилдээ эдэлж байгаа талаар тодорхой бичих, санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид гаргах хүсэлтэд банк, картын дугаар, дансны дугаарыг зөв бичих/	
3	Иргэний үнэмлэх, хуулбарын хамт	Иргэний үнэмлэхийг хуулбарын хамт авч ирэх, ТУБ эх хувьтай тулгаж, хуулбар дээр тэмдгээ дарж баталгаажуулах	Иргэний үнэмлэхийг нотариатаар гэрчлүүлсэн байх
4	Нийгмийн даатгалын дэвтэр, хуулбарын хамт	Нийгмийн даатгалын дэвтрийг хуулбарын хамт авч ирэх, ТУБ эх хувьтай тулгаж, хуулбар дээр тэмдгээ дарж баталгаажуулах	Нийгмийн даатгалын дэвтрийг нотариатаар гэрчлүүлсэн байх
5	Үл хөдлөх, эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ	Үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх газраас тухайн татвар төлөгч хувь хүнд олгосон “Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ”-г хуулбарын хамт авч ирэх, ТУБ эх хувьтай тулгаж, хуулбар дээр тэмдгээ дарж баталгаажуулна. Гэрчилгээг эх хувиар авч ирээгүй тохиолдолд нотариатаар гэрчлүүлсэн байх	
6	Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр	Дэвтэрт орлого олгон суутган тооцоолол хийсэн этгээд тэмдэглэл хийж гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна. Хуулбарын хамт авч ирэх, Татварын улсын байцаагч эх хувьтай нь тулгаж, хуулбар дээр тэмдэг дарж баталгаажуулах	Дэвтэрт орлого олгон суутган тооцоолол хийсэн этгээд тэмдэглэл хийж гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Дэвтрийг нотариатаар гэрчлүүлсэн байх
7	Ажил олгогчоос олгосон цалингийн тооцооллын хүснэгт	Хүснэгтэд овог нэр, албан тушаал, цалингийн дүн, суутгуулсан албан татварын мэдээллийг оруулж санхүүгийн тэмдэг, гарын үсгээр баталгаажсан байх	

2. Албан татвар төлөгчийн төрсөн буюу үрчилсэн хүүхэд гадаад, дотоодын их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид элсэн суралцаж байгаа бол түүний сургалтад төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр " албан татварын хөнгөлөлтийг үзүүлэхэд /ХХОАТТХ-ийн 24.6/

Д/д	Бүрдүүлэх баримтууд	Бүрдүүлэх баримтад тавих шаардлага	
		Бичиг баримтыг өөрийн биеэр татварын албанд авч ирэх	Шуудангаар хүргүүлэх
1	Харьяа татварын албанаас татварын цахим тайлангийн системд тайлан шивэх нууц үг авах	Хувь хүний орлогын албан татварын тайлан ТТ-06 (а), ТТ-06 (б) маягтыг цахим татварын системээр тайлагнаж хэвлэж авах	
2	Хөнгөлөлтөд хамрагдах иргэний 1. харьяа татварын албанд 2. санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид гаргасан хүсэлт	Хүсэлтийг www.mta.mn сайтад Хувь хүн цэсний ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлт дотор Тайлангийн маягт, өргөдлийн загвар хэсэгт байршуулсан нэгдсэн загвараар бичнэ. / татварын албанд гаргасан хүсэлтэд сургалтын төлбөрт төлсөн орлогын эх үүсвэрийг тодорхой бичих, санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид гаргах хүсэлтэд банк, картын дугаар, дансны дугаарыг зөв бичих/	
3	Хүүхдийн төрсний гэрчилгээ эсхүл үрчилсэн гэрчилгээ, хуулбарын хамт	Хүүхдийн төрсний гэрчилгээ эсхүл үрчилсэн гэрчилгээг хуулбарын хамт авч ирж эх хувьтай тулгаж баталгаажуулах	Хүүхдийн төрсний гэрчилгээ эсхүл үрчилсэн гэрчилгээг нотариатаар гэрчлүүлсэн байх
4	Суралцаж буй оюутны сургуулийн тодорхойлолт	Тодорхойлолтод оюутны овог нэр, сурч буй сургууль, мэргэжлийн чиглэлийг тусгасан байх /Гадаадын их, дээд сургуульд сурч буй оюутны сургуулийн тодорхойлолт, сургалтын төлбөр төлсөн баримтыг Монгол хэлээр баталгаат орчуулгаар орчуулсан байх/	
5	Сургалтын төлбөр төлсөн баримтууд	Эцэг, эхээс хүүхдийнхээ сургалтын төлбөр төлсөн тухай хүчин төгөлдөр эх баримтууд байна. Хэрэв онлайнаар төлсөн бол баримтыг банкаар эсвэл тухайн сургуулийн санхүүгийн албаар баталгаажуулсан байна.	
6	Харьяа татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлж татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр авах /Хорооны тодорхойлолт, иргэний үнэмлэхний хуулбар, 2 хувь цээж зураг бүрдүүлж харьяа татварын албанаас авах	Дэвтэрт орлого олгон суутган тооцоолол хийсэн этгээд тэмдэглэлийг хийж гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулна. Хуулбарын хамт авч ирэх, Татварын улсын байцаагч эх хувьтай нь тулгаж, хуулбар дээр тэмдэг дарж баталгаажуулах	Дэвтэрт орлого олгон суутган тооцоолол хийсэн этгээд тэмдэглэл хийж гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Дэвтрийг нотариатаар гэрчлүүлсэн байх
7	Ажил олгогчоос олгосон цалингийн тооцооллын хүснэгт	Хүснэгтэд овог нэр, албан тушаал, цалингийн дүн, суутгуулсан албан татварын мэдээллийг оруулж санхүүгийн тэмдэг, гарын үсгээр баталгаажсан байх	
8	Нийгмийн даатгалын дэвтэр	Нийгмийн даатгалын дэвтрийг хуулбарын хамт авч ирэх, ТУБ эх хувьтай тулгаж, хуулбар дээр тэмдгээ дарж баталгаажуулах	Нийгмийн даатгалын дэвтрийг нотариатаар гэрчлүүлсэн байх
9	Орлого нотлох бусад баримт	Орлогын эх үүсвэрээс шалтгаалан холбогдох нотлох баримтуудыг авч ирэх	

**3.Суралцаж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийн орлогоосоо албан татвар төлж, улмаар сургалтын төлсөн их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль, коллежид суралцагчийг энэ хуулийн 24.6-д заасан" хөнгөлөлтийг эдлүүлэхдээ /ХХОАТТХ-ийн 24.7/**

Д/д	Бүрдүүлэх баримт	Бүрдүүлэх баримтуудад тавигдах шаардлага
-----	------------------	--

		<b>Бичиг баримтыг өөрийн биеэр татварын албанд авч ирэх</b>	<b>Шуудангаар хүргүүлэх</b>
1	Харьяа татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлж татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр авах /Хорооны тодорхойлолт, иргэний үнэмлэхний хуулбар, 2 хувь цээж зураг бүрдүүлж харьяа татварын албанаас авах /	Дэвтэрт орлого олгон суутган тооцоолол хийсэн этгээд тэмдэглэл хийж, гарын үсэг зурж, тэмдэгээр баталгаажуулна. Хуулбарын хамт авч ирэх, Татварын улсын байцаагч эх хувьтай тулгаж, хуулбар дээр тэмдэг дарж баталгаажуулах	Дэвтэрт орлого олгон суутган тооцоолол хийсэн этгээд тэмдэглэл хийж гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Дэвтрийг нотариатаар гэрчлүүлсэн байх
2	Харьяа татварын албанаас татварын цахим тайлангийн системд тайлан шивэх нууц үг авах	Хувь хүний орлогын албан татварын тайлан ТТ-06 (а), ТТ-06 (б) маягтыг цахим татварын системээр тайлагнаж хэвлэж авах	
3	Хөнгөлөлтөд хамрагдах иргэний 1. харьяа татварын албанд 2. санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид гаргасан хүсэлт	Хүсэлтийг www.mta.mn сайтанд Хувь хүн цэсний ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлт дотор Тайлангийн маягт, өргөдлийн загвар хэсэгт байршуулсан нэгдсэн загвараар бичнэ. / сургалтын төлбөрт төлсөн орлогын эх үүсвэрийг тодорхой бичих, санхүүгийн асуудал эрхэлсэн нэгжид гаргах хүсэлтэд банк, картын дугаар, дансны дугаарыг зөв бичих/	
4	Оюутны иргэний үнэмлэх, хуулбарын хамт	Иргэний үнэмлэхийг хуулбарын хамт авч ирэх, ТУБ эх хувьтай нь тулгаж, хуулбар дээр тэмдгээ дарж баталгаажуулах	Иргэний үнэмлэхийг нотариатаар гэрчлүүлсэн байх
5	Сургалтын төлбөр төлсөн баримтууд	Сургалтын төлбөр төлсөн эх баримт, хуулбарласан тохиолдолд эх хувьтай тулгаж үзэх, Хэрэв онлайнаар төлсөн бол баримтыг банкаар эсвэл тухайн сургуулийн санхүүгийн албаар баталгаажуулсан байна.	
6	Оюутны сургуулийн тодорхойлолт	Тодорхойлолтод оюутны овог нэр, сурч буй сургууль, мэргэжлийн чиглэлийг тусгасан байх	
7	Нийгмийн даатгалын дэвтэр	Нийгмийн даатгалын дэвтрийг хуулбарын хамт авч ирэх ТУБ эх хувьтай нь тулгаж тэмдэг даран баталгаажуулна.	Нийгмийн даатгалын дэвтрийг нотариатаар гэрчлүүлсэн байх,
8	Ажил олгогчоос олгосон цалингийн тооцооллын хүснэгт	Хүснэгтэд овог нэр , албан тушаал , цалингийн дүн , суутгуулсан албан татварын мэдээллийг оруулж санхүүгийн тэмдэг, гарын үсгээр баталгаажсан байх	